

**ЗАВХАН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 07 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

1.1.Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлыг 2 удаа хийж Миний гоё сум төслийн хүрээнд сумдад санхүүгийн дэмжлэг үзүүлэх хуваарийн тухай, Сүм хийд байгуулах, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох тухай, Аймгийн Хүндэт иргэн цол тэмдгээр шагнах тухай, Хөрөнгө актлах, балансаас балансад шилжүүлэх, худалдах хөрөнгийн доод үнэ тогтоох тухай, Бүсчилсэн хөгжлийн баримт бичигт аймгаас тусгах саналын тухай, Засгийн газрын 2019 оны 249 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах тухай Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явц зэрэг асуудлуудыг хэлэлцэж 9 тогтоол гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлж хэрэгжилтийг хангуулж байна.

Завхан аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Хууль шүүхийн байгууллагуудтай хамтран хууль сурталчлах нэгдсэн арга хэмжээ, тодорхой төрлийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулсан. Тухайлбал "Хурд" "Яараад яахав дээ" "Мотоцикл" "Ааваа, ээжээ битгий яараарай", хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулж, зам тээврийн осол, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэн ажиллалаа.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах тэдэнд нөхөн олговор олгох тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нөхөн олговор авах талаар улсын бүртгэлд материал бүрдүүлэн хуулийн өөрчлөлтөд хамаарах 2 иргэний материалыг судалж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Аймгийн ИТХ-ын даргын баталсан захирамжийн дагуу сумдаас мэдээ, тайланг хүлээн авч аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 95 тогтоолын дагуу мэдээ тайланг хүлээн авч нэгтгэл хийж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг нийт иргэдэд, танилцуулж мэдээллээр хангах онлайн сургалтыг 2019 оны 07 дугаар сарын 16-ний өдрийн 14 цагт аймгийн ИТХ-ын дэргэдэх иргэний танхимд зохион байгуулсан. Уг сургалтад аймгийн ЗДТГ-ын дарга, ИТХ-ын хэлтсийн дарга, АЗДТГ-

ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, сумдын ЗДТГ-ын дарга, сумдын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нар хамрагдлаа.

1.2. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Тулгар төрийн 2228, Их Монгол Улсын 813, Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 98, Сүхбаатарын нэрэмжит Алтангадас одонт Завхан аймаг үүсэн байгуулагдсаны 96 жилийн ойн баяр наадам долдугаар сарын 9, 10, 11-ний өдрүүдэд боллоо. Үндэсний их баяр наадмын нээлтийн үйл ажиллагаа долдугаар сарын 10-ний өдөр болсон юм. Энэ үеэр “Эко Завхан”, “Бүтээн байгуулалт-14” аянуудыг дүгнэж шилдэг сум, байгууллагуудыг шалгарууллаа. “Эко Завхан” аяны хагас жилийн дүнгээр Шилүүстэй сум тэргүүн байр, Яруу сум хоёрдугаар байр, Цэцэн-Уул сум гуравдугаар байрт орсон. Шилдэг эко байгууллагаар Аймгийн Онцгой байдлын газар, хоёрдугаарт Аймгийн нэгдсэн эмнэлэг, гуравдугаарт аймгийн хүүхдийн V цэцэрлэг орсон бол эко хэвлэлийн байгууллагаар Завхан сонин шалгарлаа.

Аймгийн баяр наадмын үеэр баярын хурал, хүндэтгэлийн концертыг зохион байгуулсан юм. Ардын хувьсгалын 98 жилийн ойг тохиолдуулан Завхан аймгийн 130 гаруй иргэн төрийн дээд одон медалиар шагнууллаа.

Үндэсний их баяр наадмаар Улсын харцага М.Дармаабазар, Улсын өсөх идэр начин Ц.Сумьяабэйс, Улсын начин Д.Бадамдорж, Улсын начин Г.Бат-Амгалан тэргүүтэй улс аймгийн алдар цолтой бөх зодоглосноос аймгийн начин 3, аймгийн харцага 1, Аймгийн арслан 1 төрлөө. Бөхийн барилдааны шөвгийн дөрөвт Аймгийн заан М.Лхагвагэрэл, Аймгийн харцага Ш.Чинтулга, Аймгийн нэмэх начин М.Амарсанаа, Аймгийн начин Э.Шийрэвнямбуу нар үлдсэн юм. Завхан аймгийн баяр наадмын үндэсний бөхөд Аймгийн нэмэх начин М.Амарсанаа түрүүлж аймгийн арслан цол хүртэж, Аймгийн заан М.Лхагвагэрэл үзүүрлэж заан цолоо баталлаа. Мөн бөхийн барилдааны өмнө бөхчүүд тангараг өргөдөг уламжлал Завхан аймагт тогтсон юм. Бөхчүүд тангараг өргөснөөр бөх найраагүй, будлиангүй болдог.

Завхан аймгийн хувьд эрийн гурван наадмын нэг болох сур харваанд анхааран ажиллаж 1500 гаруй харваачийг бэлтгэсэн. Энэ жилийн наадмын сур харвааны насанд хүрэгчдийн ангилалд 82 харваач, өсвөр насны ангилалд 78 харваач оролцож аймгийн мэргэн 2, аймгийн Идэр мэргэн нэг төрлөө. Мөн шагай харвааны тэмцээнийг зохион байгуулж Яруу сумын баг тэргүүн байрт шалгарсан юм.

Завхан аймаг үүсэн байгуулагдсаны 96 жилийн ойн баяр наадмын үеэр “Завхан ногоон гарц нэгдэл” ТББ-аас “Байгальд ээлтэй наадъя” уриаг дэвшүүлж ажилласан. Энэхүү ажлын хүрээнд Завхан аймгийн Улиастай сумын ерөнхий

боловсролын сургуулийн 40 сурагч сайн дурын үндсэн дээр баяр наадмын талбайд ил хаясан хогийг түүж ангилан ялгасан юм.

Америкийн Нэгдсэн Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Батлан хамгаалахын атташейн албаны ажилчид манай аймагт 2019 оны 07 дугаар сарын 23-24-ны өдрүүдэд ажиллаа. Энэхүү ажлын хүрээнд аймгийн удирдлагуудтай уулзаж хоёр талын хамтын ажиллагааны талаар саналаа солилцон, эрүүл мэнд, боловсролын салбарт хамтран ажиллах боломжтойг дурдсан юм.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:

2.1.Төсвийн орлого, зарлага: Аймгийн хэмжээгээр 2019 оны эхний хагас жилд төсөвлөгдсөнөөр 46 тэрбум 961.5 сая төгрөг, зарлага 39 тэрбум 841.7 сая төгрөгт хүрсэн байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 12.8 хувь буюу 4 тэрбум 523.0 сая төгрөгөөр өссөн байна.

Татварын орлого:Татварын орлогын төлөвлөгөө аймгийн дүнгээр 123.8 хувийн биелэлттэй, 3 тэр бум 611.7 сая төгрөгийн орлого оруулсаны цалин хөлс, түүнтэй адилтгах орлого 74.5 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 6.2 хувь, ашигт малтмал ашигласаны төлбөр 5.6 хувь, бусад нэр төрөл 13.7 хувийг тус тус эзэлж байна. Нийт татварын орлогын бүрдүүлэлтийн 65.8 хувь буюу 4 тэрбум 591.7 сая төгрөгийг орон нутгийн орлого, 34.2 хувь буюу 2 тэр бум 381.7 сая төгрөгийг улсын төсвийн орлого бүрдүүлж байна.

Монгол банкны мэдээгээр хагас жилд гүйлгээнд 3 тэрбум 345 сая төгрөг, иргэдийн мөнгөн хадгаламжинд 65.7 мянган иргэний 101.2 тэрбум төгрөг байгаа нь иргэдийн мөнгөн хадгаламж өнгөрсөн оны мөн үеэс 16.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Аймгийн дүнгээр 65.2 тэрбум төгрөгийн зээл олгосон нь өнгөрсөн оны мөн үеэс 1.9 хувь буюу 1.3 тэрбум төгрөгөөр буурсан байна. Зээлийн сарын хүүг арилжааны банкуудаар авч үзвэл дунджаар ХААН банк 1.5%, Хас банк 1.58%, Төрийн банк 1.44%, байна.

Гурав. Хууль зүйн бодлогын хүрээнд:

3.1. Гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл: Аймгийн хэмжээгээр 126 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 25.3 хувийг иргэдийн эрх чөлөө эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 37.3 хувь нь бусдын өмчлөлийн эсрэг гэмт хэрэг, 37.4 хувийг бусад төрлийн гэмт хэрэг эзэлж, өнгөрсөн оны мөн үеэс гэмт хэргийн тоо 11-ээр буюу 12.7 хувиар өссөн байна.

Эхний хагас жилд гэмт хэргийн улмаас 7 хүн нас барж, 40 хүн гэмтэж 202.3 сая төгрөгийн хохирол учирсан байна. Оны эхнээс өссөн дүнгээр 6370 зөрчил

илрүүлж, 250 хүн эрүүлжигдэн, 130 хүн баривчлагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс зөрчил 3794-өөр, баривчлагдсан хүн 9-өөр тус тус нэмэгдэж эрүүлжигдсэн хүн 96-аар буурсан байна.

3.2. Архивын ажлын мэдээлэл: Ашиглалтын хувь үүсгэх ажлын хүрээнд 10 хөмрөг, 10 данс, 167 хадгаламжийн нэгжийн 5521 хуудас баримтыг сканердаж, 10 хөмрөг 10 дансны 167 хадгаламжийн нэгж, 5521 хуудас баримтыг photoshop програмд засварлалаа.

5 хөмрөг, 5 данс, 73 хадгаламжийн нэгжийн удирдлагын баримт бичгийг баримтын түвшинд тодорхойлон бичиж, тоо бүртгэлийн програмд оруулах ажлын хүрээнд 2355 хуудас баримтаас 1976 заалт, 2817 хүний нэр, газарзүйн нэр 50 программд шивж 73 PDF файл үүсгэн эх баримтыг холболоо.

209 иргэн, 4 байгууллагын хүсэлтийг хүлээн авч 355 баримт шүүж, 75 хуулбар, 111 лавлагаа 23 тодорхойлолт олгож төрийн үйлчилгээ үзүүллээ.

11 хөмрөгийн 501 хадгаламжийн нэгж баримтыг иж бүрэн нягтлан шалгаж техник боловсруулалт хийсэн.

Төрийн архивыг 2019 онд нөхөн бүрдүүлэх төлөвлөгөө, хуваарийн дагуу 9 хөмрөгийн 192 хадгаламжийн нэгж хүлээн авлаа.

Төрийн архивын 34 хөмрөгийн баримтанд иж бүрэн нягтлан шалгалт хийж данс бүртгэлийг шинэчилсэн 68 бүртгэл, 102 актыг хянаж баталгаажуулан хөмрөгийн хэрэгт байршуулсан.

Төрийн архивыг 2019 онд нөхөн бүрдүүлэх төлөвлөгөө, хуваарийн дагуу 8 хөмрөгийн 54 хадгаламжийн нэгж хүлээн авлаа.

3.3.Онцгой байдал: Онцгой байдлын газрыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 18 дугаар тогтоолоор дэслэгч генерал Г.Дамдинсүрэнгийн нэрэмжит болгох ёслолын арга хэмжээ болон хөшөөний нээлтийн үйл ажиллагааг 06 дугаар сарын 28-ний өдөр зохион байгууллаа.



Дээрх арга хэмжээнд Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын дарга, хурандаа Ц.Нямбаяр, Аймаг орон нутгийн удирдлага, болон дэслэгч генерал Г.Дамдинсүрэн агсны гэр бүл, үр хүүхдүүд, нутгийн ард иргэд оролцсон.

2019 оны 06 дугаар сарын 28-ний өдөр Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Т.Бадрал, Гал түймэртэй тэмцэх газрын дарга, хурандаа Ц.Нямбаяр нар Улиастай сум дахь Гал түймэр унтраах, аврах 43 дугаар ангийн галын



депогийн барилгын

гадна, дотор талын тохижилт бүтээн байгуулалтын ажилтай танилцаж алба хаагчидтай уулзаж санал хүсэлтийг сонсч, Онцгой байдлын байгууллагаас

авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл хийж Онцгой байдлын албаны 15 жилийн ойг тохиолдуулан ажилдаа амжилт гаргасан зарим алба хаагчдыг шагнаж урамшуулсан.



Орон нутгаас зохион байгуулсан “Миний гоё сум” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдаж буй “ЭКО ЗАВХАН” аянд оролцож “Шилдэг эко байгууллага”-аар шалгарч Өргөмжлөл, 1.000.000 төгрөгөөр шагнуулсан.

Үндэсний их баяр наадам Ардын хувьсгалын 98 жилийн ойг тохиолдуулан 2019 оны 07 дугаар сарын 10-ний өдрийн 09 цагаас 07 дугаар сарын 16-ны өдрийн 09 цаг хүртэл албаны хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллалаа.

Онцгой байдлын газар, Улсын нөөцийн салбар, Гал түймэр унтраах аврах 39, 43, 57 дугаар ангиудын алба хаагчдыг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт үүрэг гүйцэтгэх 1, 2 дугаар бэлтгэл ээлжийг томилгоожуулан хүн нэг бүрийн хувийн бэлтгэлийг шалгаж, гал унтраах техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдалд үзлэг шалгалт явуулан албаны хэмжээнд нийт 22 офицер 89 ахлагч гал унтраах болон шуурхай албаны 18 авто машинтай үүрэг гүйцэтгэлээ.

Баяр амралтын өдрүүдэд үүрэг гүйцэтгэсэн талаар онцгой байдлын ерөнхий газрын гамшгаас урьдчилан сэргийлэх газарт илтгэх хуудсаар хүргүүлсэн.

Сонгино сум дахь шатахууны цэгийг түшиглэн Улаанбаатар-Увс аймгийн чиглэлийн хатуу хучилттай төв зам дагуу байрлалд барих Шатахуун түгээх станц,

Аврах бүлэг байгуулах газрын загвар, зай хэмжээний, өндөржилтийн, картограмм зураг, инженер геологийн дүгнэлт зэргийг гаргуулсан.

Сонгино сум дахь “Шатахуун түгээх станц” болон “Аврах бүлгийн байр барих газарт улаан шугам татах ажлыг “Молонгоо” ХХК-ийн гаргасан зургийн дагуу Петровис ХХК-ийн инженер Балжиннямын хамтаар шатахууны цэгийн алба хаагчид өндөржилт, зай хэмжээг татаж барилгын тэг тэнхлэгийг татаж тэнхлэгүүдийн хуваарийг гадсаар тэмдэглэн тэмдэг тэмдэглэгээг хийж байрлуулсан.

Өндөржилт эхлэхийн өмнөх хил хязгаарыг тогтоох хэмжилтийг 21 цэгт хийж хэмжилт хийсэн цэг бүрийг холбож нүүрсний нунтаг хогоор тэмдэглэн үлдээсэн.

Энэ сард Ардын хувьсгалын 98 жилийн ой баяраар цэнгэлдэх хүрээлэнгийн орчимд хоол бэлтгэх, үйлчилгээний зориулалтаар түр баригдсан 21 гэрүүдийг шалгаж Галын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 20 мэдэгдэл хүргэж гарын үсэг зуруулж баталгаажуулан баярын өдрүүдэд үзлэг шалгалтыг зохион байгуулан ажиллалаа.

2019 оны 07 дугаар сарын 07-10-ны өдрүүдэд хүн ам олноор цуглардаг “Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төв”, “Баруун бүсийн худалдааны төв”, “Улиастай” зах, “Жаргал” худалдааны төв, “Эрхэм оргил” худалдааны төв, “Баянбүрд” худалдааны төв, “Завхан” зочид буудал, “Улиастай” зочид буудал зэрэг нийт 12 газарт галын түймрийн улсын хяналт шалгалтыг зохион явуулж илэрсэн зөрчил дутагдалыг газар дээр нь арилгуулан ажиллалаа.

Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу Ургамал, Завханмандал, Дөрвөлжин, Эрдэнэхайрхан, Сонгино, Нөмрөг сумдын нутаг дэвсгэрт Уул, уурхай болон зам угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 11 газарт гал түймрийн улсын хяналт шалгалт зохион явуулж галын аюулгүй байдлаа хангаагүй 2 газарт 2 сая төгрөгийн торгууль оногдуулж зөрчлийн арга хэмжээ авсан.

Дээрх зөрчил дутагдлуудыг арилгуулахаар Заавал биелүүлэх албан шаардлага 5, Ажлын байрны галын аюулгүй байдлын зөвшөөрөл 11, Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт 3, Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа 2 удаа явуулж шалгалтын дүнгийн талаар шалгалтад хамрагдсан газруудын удирдлагуудад танилцуулж зөрчлийг арилгуулах талаар үүрэг чиглэл өгч ажиллаа.

Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

4.1. Боловсрол, соёлын чиглэлээр: Судлагдахуун бүрээс шилдэг арга зүйтэй, бусдад түгээн дэлгэрүүлж болохуйц, “Сайн хичээл, үйл ажиллагаа”-нд

заагдан сайжруулсан шилдэг ээлжит хичээлийн хөтөлбөрийг мэргэжилтнүүд ЕБС-ийн багш нараас авч нэгтгэлээ.

Математик, Физик, Мэдээллийн технологийн 21, Хими, биологийн 23, Англи хэлний 5, Бага боловсролын 14, Хөгжмийн 4, Технологийн 3, Нийгэм, түүх, газар зүйн 6, Монгол хэл, уран зохиолын 5 нийт 81 сайн арга зүйн туршлага бүхий хөтөлбөрөөр “Багшлах арга зүй 1,2,3” 120 ширхэг эмхтгэлийг хэвлэн гаргалаа.

АХБ-ны "Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дэмжих төсөл", "Эдийн засгийн хүндрэлтэй үед боловсролын чанар хүртээмжийг сайжруулах төслийн санхүүжилтээр VIII/20-VIII/23-нд БСШУСЯ, БМДИ, БХ, БҮТ хамтран “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх арга зүй” сургалт (ЕБС, СӨББ)-ын зохион байгуулалтын хуваарь, 1288 багш сургалтанд хамрагдах анги танхим, зохион байгуулалтын судалгааг гарган БМДИ, ЕБ-ын сургуулиудад хүргүүллээ.

Цэцэрлэгийн 18 багш бүжиглэх, 200 хүүхэд хөдөлгөөнт гимнастик хийх, 90



хүүхэд шүлэг унших, 33 хүүхэд морин хуур тоглох бэлтгэл ажлыг хангуулж ажиллан аймгийн баяр наадмын нээлтийн үйл ажиллагаанд амжилттай оролцлоо.

"Сурган заах арга зүйн кабинет " үүсэж хөгжсөний 60 жилийн ойд зориулсан түүхэн баримтат кино хийх бэлтгэл ажлын хүрээнд ахмад ажилтан, үе үеийн удирдлагуудаас ярилцлага, мэндчилгээ авах, түүхэн материалыг цуглуулан телевизэд өгөх ажлууд хийгдэн киноны монтажнаас бусад ажил 90%-ийн гүйцэтгэлтэй байна.

4.2.Эрүүл мэнд, спортын чиглэлээр: “Халдварын сэргийлэлт хяналт” сэдэвт баруун бүсийн сургалтыг Завхан аймгийн Эрүүл мэндийн газар, АШУҮИС, Монголын Гастроэнтерологийн Холбоо, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй хамтран 100 гаруй эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд зохион байгуулсан.

2019.07.09-2019.07.16-ний баярын өдрүүдэд хариуцлагатай жижүүр томилон эрүүл мэндийн байгууллагууд шуурхай байдлыг ханган ажиллаж харьяа эрүүл мэндийн байгууллагуудаас цаг тухай бүрт мэдээг авч нэгтгэн эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн. Тухайн баярын амралтын өдрүүдэд Амбулаториор ирж үйлчлүүлсэн иргэдийн тоо 801, Түргэн тусламжийн дуудлагын тоо 371, Нийтийг хамарсан ноцтой тохиолдол, осол гэмтэл 8, нас баралт 4 тохиолдол гарсан. Нийт 33 эх төрснөөс гэрийн төрөлт 1, амьд төрөлт 33 үүнээс хүү 17, охин 16 төрсөн байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хурлаар “Халдварт өвчинтэй тэмцэх аймгийн дэд хөтөлбөр”-ийн үйл ажиллагааны биелэлтийг тайлагнасан.

“Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд ЭМЯ-аас ирсэн хугацаат шалгалтад бэлтгэн, сум тус бүрээр 15-39, 40-65, 65-аас дээш насны ангиллаар хамралтын мэдээ, илрүүлэг оношилгоо, шинжилгээгээр илэрсэн гепатит В, С, В+С вирүстэй иргэдийн судалгаа, Гепатитийн В, С, В+С вирүстэй иргэдийн эмчилгээнд хамрагдсан талаархи судалгаа 2017-2019 он хүртэлх мэдээ, мэдээллийн санг үүсгэн хавтасжуулж ажилласан.

Баяр наадмын өдрүүд болон урин дулааны улиралд хоол хүнсний хордлого, осол гэмтлээс сэргийлэх зорилгоор иргэд, аж ахуй нэгжид цахим мэдээллийн хэрэгслээр “Хоол хүнсний хордлогоос сэргийлье”, “Гэдэсний халдвараас сэргийлье”, “Аюулгүй хоол хүнсний түлхүүр зарчим”, “Наранд цохиулахаас сэргийлээрэй”, “Осол гэмтлээс сэргийлье”, “Могойд хатгуулахаас сэргийлье” зэрэг 7 төрлийн мэдээллийг дамжуулан 5985 иргэн хандалт хийсэн байна.

Анхан шатны эрүүл мэндийн төвүүдээр үйлчлүүлж буй иргэдэд “Хоол хүнсний хордлогоос сэргийлье”, “Гарын ариун цэвэр” , “Гэдэсний халдварт өвчин” зэрэг сэдвүүдээр 246 иргэнд мэдээлэл хийж 245 ширхэг сурталчилгааны материал тараасан байна.

“Жирэмсний хяналтыг сайжруулах”, “Бэлгийн замаар дамжих халдварыг бууруулах” зэрэг аяныг зарлан харьяа эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн.

Дэлхийн гепатитийн өдрийн хүрээнд 7 сарын 26-ны 12:00 цагт Баруун бүсийн худалдааны төвийн урд талбайд аймгийн ЭМГ, АНЭ, ӨЭМТ-үүдтэй хамтран “Гепатитийг устгах ажилд хувь нэмэр оруулъя” уриан дор зохион байгууллаа. Өдөрлөгөөр:

- Иргэдэд В, С вирүсийн халдвараас урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгаа, 5 төрлийн мэдээлэл бүхий 200 ширхэг гарын авлага тараасан.
- 15-аас дээш насны 200 иргэнийг гепатитийн В, С вирүсийн халдвар илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамруулан, мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан.

Эрүүл мэндийн газрын даргын 2019 оны 06 дугаар сарын 13 өдрийн А/28 дугаар тушаалаар батлагдсан үнэлгээний хороо нь аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн **“Хүүхдэд ээлтэй ус хангамж, ариун цэврийн байгууламжийн**

шинэчлэл” хийх ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах 09-ХА/001/2019 дугаартай нээлттэй тендер шалгаруулалтыг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу явуулж Цагаан сээр ХХК, Баялаг сор ХХК-ууд тендерийн материал ирүүлсэн байна. Хамгийн сайн үнэлэгдсэн компаниар Цагаан сээр ХХК гэрэ байгуулах эрх олгосон.

Нийгмийн даатгал, халамж

Аймгийн хэмжээгээр нийгмийн даатгалын сангаас эхний хагас жилд 11.2 мянган хүнд 23.7 тэр бум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгож, 10.5 тэр бум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Эхний хагас жилд 64433 хүн нийгмийн даатгалд хамрагдсаны 60957 буюу 95.0 хувь нь төсөвт байгууллага, ААНэгж байгууллагын даатгуулагч, 3476 иргэн буюу 5.0 хувь нь сайн дурын даатгалд хамрагдсан байна.

Сангуудаар авч үзвэл: тэтгэврийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 21.5 хувиар, тэтгэмжийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 24.8 хувиар, ҮОМШӨ сангийн орлогын төлөвлөгөөг 44.8 хувиар, ажилгүйдлийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 42.1 хувиар тус тус давуулан биелүүлж байна.

Тэтгэвэрийн сангийн зарлага 20350.6 сая төгрөгт, Тэтгэмжийн сангийн зарлага 771.1 сая төгрөг, Эрүүл мэндийн сангийн зарлага 1842.2 сая төгрөг, ҮОМШӨ-ний зарлага 636.6 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 148.4 сая төгрөг тус тус зарцуулж нийт 23748.9 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, даатгалыг олгосон байна.

Халамжийн сангийн сангийн үйл ажиллагааны эхний хагас жилийн мэдээгээр Халамжийн тэтгэвэр 1757 хүнд 1709.5 сая төгрөг, нөхцөлд мөнгөн тэтгэмж, нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт 24567 хүнд 3920.8 сая төгрөг нийт 26324 хүнд 5630.3 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлтийг үзүүлсэн байна.

Хөдөлмөр эрхлэлт

Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй хүний тоо 786 болж, өнгөрсөн оны мөн үеэс 62.1 хувиар буюу 479 хүнээр буурсан байна. Аймгийн хэмжээнд 429 эмэгтэй ажил идэвхитэй хайж байгаа нь ажилгүйчүүдийн 55 хувийг эзэлж байна.

2019 оны 6 сарын байдлаар бүртгүүлсэн, ажил идэвхитэй хайж байгаа ажилгүйчүүдийн тоо өмнөх 4 жилийн дунджаас 58 хувиар буюу 573 хүнээр буурсан байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 18 хувь нь 15-24 нас, 30 хувь нь 25-34 нас, 26 хувь нь 35-44 нас, 22 хувь нь 45-54 нас, 2 хувь нь 55-59 нас, 2 хувь нь 60 дээш насны ажилгүйчүүд байна.

Ажилгүйчүүдийн 1.7 хувь нь боловсролгүй, 3.7 хувь нь бага, 9.8 хувь нь суурь, 51.5 хувь нь бүрэн дунд, 5.3 хувь нь техникийн болон мэргэжлийн, 4.7 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 23.3 хувь нь дээд боловсролтой хүмүүс тус тус эзэлж байна.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд: Аймгийн хэмжээнд 7 сарын 1-ний байдлаар оны эхний төллөх насны 1501.4 мянган хээлтэгч малын 1312.6 мянга (87.4%) нь төллөжээ. Гүүний 78.6 хувь, үнээний 81.6 хувь, ингэний 46.4 хувь, эм хонины 90.3 хувь, эм ямааны 85.3 хувь нь төллөж байна. Төллөлтийн хувь өмнөх оноос 15.9 пунктээр өссөн байна. Гарсан төлийн 98.9 хувь буюу 1298.6 мянган төл бойжиж байна. Төл бойжилтын хувь өмнөх оноос 2.0 пунктээр өссөн байна.

Эхний хагас жилд аймгийн дүнгээр 18.2 мянган том мал зүй бусаар хорогдсон нь оны эхний малын 0.5 хувь, нийт хорогдолд өвчний хорогдол 0.07 хувь, хээлтэгч малын хорогдол 11.6 хувь, бог малын хорогдол 83.2 хувийг тус тус эзэлж байна. Том малын зүй бусын хорогдлыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 157.8 мянгаар буюу 9.6 дахин буурсан байна.

Аймгийн хэмжээнд 7 сарын 1-ний байдлаар 3371.1 га талбайд тариалалт хийснээс үр тариа 1713.0 га-д, төмс 204.0 га-д, хүнсний ногоо 157.8 га-д, малын тэжээл 1296.3 га-д тус тус тариалсан байна.

Өмнөх оны мөн үеийнхээс нийт тариалсан талбай 900.1 га буюу 36.4 хувь, үүнээс үр тарианых 233.0 га буюу 15.7 хувь, хүнсний ногоо 20.0 га буюу 14.5 хувь, малын тэжээл тариалсан талбай 651.3 га буюу 2 дахин тус тус өсч, төмс 4.2 га буюу 2.0 хувиар буурсан байна.

НҮБ-ын Хувийн хэвшлийн оролцоотойгоор “Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн болон хүнсний ногооны үйлдвэрлэлийн нэмүү өртөгийн сүлжээг хөгжүүлэх” төслийн Зохицуулагч Г.Ганхөлөг, Хүнсний ногооны зөвлөх Чойжилсүрэн нар 2019 оны 07 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд Лааны булан, Ногоон хашаа, Өндөр толгойн услалтын системд улаан хальст сармис тариалж байгаа тариаланчтай уулзаж төслийн хүрээнд хамтран ажиллах талаар санал солилцсон.

Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн “Хөдөө аж ахуйн салбарын 2019-2020 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 285 дугаар тогтоолын биелэлтийг хангуулах зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлж байна.

“Ногоон алт” Малын эрүүл мэнд төсөл хэрэгжиж байгаа Баянтэс, Сантмаргаз, Шилүүстэй, Эрдэнэхайрхан сумдын мал үржил хариуцсан мэргэжилтнүүдэд ХААИС –ийн багш Г.Чулуунбат “Сүргийн эргэлтийг малын бэлчээрийн даацад тохируулах программ”-ын сургалтыг 2019 оны 07 сарын 26-27-ны өдрүүдэд хийв.

Сумдын мэргэжилтнүүдэд хонь, тэмээний ноосыг үндэсний үйлдвэрт тушаах журмын талаар мэдээллийг өгч ажиллаа.

Баянтэс, Тэс сумын 400 гаруй адуунд үүлдэр болгох зорилгоор хянан магадлагаа хийх, баталгаажуулах ажлыг ХХААХҮЯамтай хамтран зохион байгуулсан.

2019 оны 08 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд Архангай аймгийн Их-Тамир суманд зохион байгуулагдах “Сарлаг үржүүлэгчдийн улсын зөвлөгөөн” сумдыг оролцуулхаар зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд:

6.1.Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр: Хууль бусаар амьтан агнах, ургамал түүж бэлтгэхээс урьдчилан сэргийлэх зөвлөмж бэлтгэж цахим сүлжээгээр суртчилан, сумдад чиглэл хүргүүлсэн.

ИРГЭДИЙН АНХААРАЛД:

Ариг таних арга:
Овог: Агаруун Төрөл: Ариг

Зүйл: Ариг нь Шилмүүс хайрсаруу, навлуур дээр бие биеэс нэгт дараж байрласан жээл навлуурны зарим хэсэгт дүрхүү нарийхан.....

Хионин ариг:
стилуус: *Мин ховор*
= Бүх шилмүүс хайрсаруу, аялхан, боргой-жимсгэнэ 2-6 үргэй (хавна 1 үргэй), залуу навлуур 1см орчим буудуу байна.

Хуурамч хионин ариг:
стилуус: *ховор*
= Бүх шилмүүс хайрсаруу, аялхан, боргой-жимсгэнэ 1 үргэй. Залуу навлуур 1.5 см-ээс буудуу байна.

Дагуур ариг:
стилуус: *Ховор*
= Шилмүүс хоёр янз: мөчрийн нэг хэсэгт дүрхүү, нөгөөд хайрсаруу, хаана аль нэг нь дарагддаг.

Ямаан ариг:
стилуус: *Элбэг*
= Бүх шилмүүс аялхан дүрхүү, 3-аар тойрч байрласан.

ХОНИН АРИГ
ХУУРАМЧ ХОНИН АРИГ
ДАГУУР АРИГ
ЯМААН АРИГ

ЗАВХАН УРГАНА. ХЭНТИЙ ЗАВХАН

ИРГЭН ТА: ЗОХИХ ЗӨВШӨӨРӨЛГҮЙ АРИГ ТҮҮВЭЛ
Зөрчдгийн тухай хуулийн 17.1 дэх хэсэг:
Зохих зохиоворчдугаар, зохиоворчдугаар хуулий, хэмжээ, урмал түүж бэлтгэх зорил зориулалттай хэргийг зохиоворчдугаар түүж эзэмшсэн, үйлдвэрлэлийн түүхий эз болсон амьтныг, өвчинг эзэмшсэн түүхийг, бэлтгэсэн, худалдсан бол хуулийн 180.000 төгрөгөөр, хуулийн тэтгэвэр 1.500.000 төгрөгөөр торлог.

Эрүүгийн хуулийн 24.8 дугаар зүйл:
Иргэн ховор, ховор урмал, тэндсгийн ур, үрхэмийг түүсэн, бэлтгэсэн, худалдсан, худалдсан, үйлдвэрлэсэн, үйлдвэрлэсэн, бэлтгэсэн бол 5.000.000- 25.000.000 төгрөгөөр торлог, хууль 1.5 жил хүртэл хугацаатай хуулиар зорчих эрхийг хасгариж, хууль 1.5 жил хүртэл хугацаатай хорих эрхийг хасгариж, хууль 1.5 жил хүртэл хугацаатай хорих эрхийг хасгариж.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН 2017 ОНЫ 08 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДРИЙН А/220 ДУГААР ТОГТ УУШАЛДАГ –ийг ХУУИЙН БОЛОН ҮЙЛДЭВЭРИЙН ЗОРИУЛАЛТАЙ АРХАНГАЙ АЙМГИЙН МОНГОЛ ОРЧИН ХЭМЖЭЭНД ЖИЛИЙН ХУГАЦААТАЙ ХОРИЛГОСОН.

ИРГЭН ТА

Зөвлөмж эдийн засгийн үнэмлэх:

Хионин ариг	Цалин	200.000 мөв
Хуурамч хионин ариг	Цалин	200.000 мөв
Дагуур ариг	Цалин	200.000 мөв
Ямаан ариг	Цалин	200.000 мөв
Завхан ургана	Цалин	200.000 мөв

АНГАМТНАА АГНАХ БУС ХАМГААЛААР!

ТӨГТӨГӨӨР ТОГТГОЛ

Баяр наадам болон сум байгууллагын ойн баярыг хоггүй цэвэрхэн тэмдэглэн өнгөрүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2019 оны 07 дугаар сарын



02-ны өдрийн “Хоггүй цэвэрхэн наадах тухай” А/220 дугаар захирамж гаргаж, төрийн бус байгууллага, эко клубын хүүхдүүдтэй хамтран баяр наамдын талбай, морь барианы газрын хогийг тогтмол цэвэрлэж, хог хаягдал ангилан ялгах сав байршуулан хоггүй цэвэрхэн наадсан.

“Эко Завхан”, “Бүтээн байгуулалт-14” аяныг аймгийн хэмжээнд 2 дахь жилдээ зохион байгуулж 2019 оны хагас жилийн байдлаар шилдэг эко сум, байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага, шилдэг бүтээн байгуулалттай сум, байгууллагыг шалгаруулж нийт 10.2 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан.



Усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх түүнийг хомсдох бохирдохоос сэргийлэх зорилгоор Идэр голын сав газар, Хяргас нуур-Завхан голын сав газруудад байрлах 15 аж ахуй нэгж, байгууллагад /жуулчны бааз-3, амралтын газар-2, хүүхдийн зуслан-1, ус хангагч байгууллага-1, усан цахилгаан станц, хувийн худаг-5, зочид буудал-1, Халуун усны газар-2/ үзлэг шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, илэрсэн зөрчлийг арилгуулахаар холбогдох сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагчид шилжүүлсэн.

Аялагч жуулчдад зориулж аймаг, сумдын баяр наадам тэмдэглэн өнгөрүүлэх цагалбар гарган сурталчилсан.

6.2. Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл эхний II улирлын байдлаар оны үнээр 12 тэрбум 105.0 сая төгрөг болж, өнгөрсөн оноос 55.7 хувиар буюу 6 тэрбум 743.2 сая төгрөгөөр өссөн нийт үйлдвэрлэлээс ААНэгжийн үйлдвэрлэл нь 7728.5 сая төгрөг, иргэдийн үйлдвэрлэл нь 4376.5 сая төгрөг болсон байна. Үйлдвэрлэлд цахилгаан, дулаан, усан хангамжийн үйлдвэрлэл 30.9 хувийг, хүнсний үйлдвэрлэл 30.3 хувь, боловсруулсан мах 23.5 хувь, хувцас үйлдвэрлэл 8.8 хувь, модон эдлэл үйлдвэрлэл 4.1 хувь, эсгий эдлэл үйлдвэрлэл 0.9 хувь, өлөн гэдэс үйлдвэрлэл 0.1 хувь, гурил үйлдвэрлэл 0.1 хувь, Болк тоосго үйлдвэрлэл 0.5 хувь, арьс шир үйлдвэрлэл 0.2 хувь, бусад үйлдвэрлэл 0.6 хувийг тус тус эзэлж байна.

6.3. Дэд бүтцийн чиглэлээр: Эхний хагас жилд барилгын салбарын мэдээнд барилга угсралт, их засвар, бүтээн байгуулалтын ажилд аймгийн дүнгээр 101 тэр бум 195,4 сая төгрөгийн ажил гүйцэтгэснийг салбараар үзвэл: Орон сууцны барилга 2 тэрбум 435.4 сая төгрөг, орон сууцны бус барилга 8 тэрбум 156.5 сая төгрөг, сургууль соёлын барилга 4 тэрбум 485.1 сая төгрөг, авто замын ажилд 89 тэр бум 685,2 сая төгрөг, их засварын ажилд 630.6 сая төгрөгийн

барилга угсралт, их засварын ажлыг гүйцэтгэсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад барилга угсралт, их засварын ажил 62.2 хувиар өссөн байна.

Орон нутагт хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээнүүдэд хяналт хийх төлөвлөгөө гарган, Улиастай суманд баригдаж буй Хөгжимт жүжгийн театр, Ундарга ХХК-ны 25 айлын орон сууц, Юм Юм ХХК-ны орон сууц, Мэргэжлийн хяналтын газрын контор, Аймгийн ЗДТГ-ын барилгын засвар, Шилүүстэй сумын эмнэлгийн засвар, 100 хүүхдийн цэцэрлэг, Алдархаан сумын 50 хүүхдийн цэцэрлэг, 6,7 км авто зам, Цэцэн-Уул сумын соёлын төв, спорт заал, хичээлийн байр, Тэс сумын ЭМТ, ЗДТГ, Баянтэс сумын соёлын төв, Сонгино сумын ЭМТ, Их-Уул сумын соёлын төв, хичээлийн байр, Яруу сумын спорт заал, Дөрвөлжин сумын цэцэрлэг, Тэлмэн сумын ЭМТ-ийн засварын ажлуудад хяналт хийж үүссэн зөрчлийг арилгуулсан.

Тэс сумын ЗДТГ-ын барилга угсралт, Дөрвөлжин сумын соёлын төвийн барилга угсралт, Яруу сумын спорт заалны засварын ажлыг улсын комиссоор хүлээн авч байнгын ашиглалтанд оруулсан.

Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх сумдын биеийн тамирын талбай, халуун ус, Улиастай сумын багуудын тоглоомын талбай, халуун усны гүйцэтгэгчүүд шалгаран гэрээ байгуулсан. Мөн 10 газрын эхлүүлэх болон үргэлжлүүлэх зөвшөөрөл өгч ажилласан.

Улиастай сумын Баазын хэсгийн цэвэр бохир усны ажлыг Ган ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд хяналтын явцад хэд хэдэн зөрчил үүссэн тул газар дээр нь зөрчлийг арилгуулан ажиллаж байна. Мөн зураг төслийн зохиогч 7 сарын 22-ны өдөр газар дээр нь ажилласан.

7 дугаар сарын 18-ны өдөр Барилга хот байгуулалтын яамны ХОСХ-ийн дарга, БХТ-ийн хяналтын инженер нар Алдархаан суманд хэрэгжих шинэ сум төслийн ажилтай танилцаж, ажлыг эрчимжүүлэх талаар шуурхай арга хэмжээ авч ажиллах талаар орон нутагт үүрэг өгч ажилласан.

Эрчим хүчний яамны төслийн баг 7 сарын 23-ны өдөр Улиастай суманд баригдах дулааны станцын талаар газар дээр нь ажиллаж, холбогдох албан тушаалтнуудтай хэлэлцүүлэг зохион байгуулав. Мөн шинээр баригдах дулааны станцын газар, шинээр төлөвлөж буй шугамын трасстай танилцаж цаашид хэрэгжүүлэх ажлын талаар орон нутагт үүрэг даалгавар өгч ажилласан.

Алдархаан сумын 6,7 км авто зам, Улиастай сумын гудамж төслийн замын ажилд замын инженерүүдийг томилон, гэрээ байгуулан өдөр тутам хяналтыг хийлгэж байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/230 дугаар захирамжаар 5 иргэнд газрыг үнэ төлбөргүй өмчлүүлж, 35 иргэнд кадастрын зургаар үйлчилсэн.

Улиастай суманд хэрэгжиж байгаа “Гудамж төсөл”-ийн хүрээнд аймгийн төвийн авто замуудыг өргөтгөх ажил эхэлж байгаатай холбогдуулан замын трасст орсон 120 гаруй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад албан мэдэгдэл, мэдээлэл хүргүүлсэн.

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР